



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/512

Булган сум

┌ Хөрөнгө гаргах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII дугаар хуралдааны XII/21 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Явган аялал-2023" арга хэмжээний хүрээнд эко аялал жуулчлалыг иргэд, аж ахуй нэгж байгууллагууд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гатөмөр)-т даалгасугай.

2. Арга хэмжээнд шаардлагатай 500,000 (таван зуун мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010521